

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 176 тоот албан бичгийн хавсралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО  
 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ /2023 он 4 дүгээр улирал/

2023 оны 11 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Д/д	ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгөн хэмжээ эх үүсвэр/аяар/	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 он	Хэрэгжилтийн хувь
<b>ХОЁР ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
<b>2.2 Биеийн тамир, спорт.</b> Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.							
1.	2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.	1	Иргэдийн бие биелүүрх түвшин тогтоох сорилын үр дүнд заавал норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, амьдралын онцлог нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	10.765.0	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 он	Хүрсэн түвшин, үр дүн 100%

Эрх зүйн орчныг бүрдүүсэн байна.

-Монгол улсын ерөнхийлөгчийн "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53 дугаар зарлигийн 1 дэх заалт, Дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/214 дугаар захирамжийн хүрээнд харьяа хэлтэс, алба, иргэдээс сорилыг авч дүн мэдээг нэгтгэнэ. Тайланг ЗГТА-БТСУХ, НБТСГ-т хургууллээ.  
 -Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд дүүргийн **50,123** иргэн хамрагдсан.  
 -Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос "Иргэдийн бие бялдрын ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох судалгаа"-г иргэдээс авах ажлын хүрээнд ДЭМБ-ын зөвлөсөн аргачлалын дагуу дүүргийн иргэдээс 5 насны бүлгийн (18-24, 25-34, 35-44, 45-54, 55-аас дээш) ангиллаар 250 иргэнээс тодорхойлох

								судалгаа авч нэгтгэн, программд шивж оруулаа.	
2.	2.2.2.Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тоглолцоог хөгжүүлнэ.	2	Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна.	2021-2024					
		3	Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт 30.000-нийцсэн 40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.	2021-2024	Улсын төсөв	ТЭЗҮ боловсруулсан байна.			
3.	2.2.3 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.	4	Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэжлүүлэн ашиглалтад оруулна.	2021-2024	Улсын төсөв /42290.2 сая төгрөг/	Нийслэлийн болон 4 дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг		-Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт цогцолборын барилгын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.	85%
		5	Захиалгын дагуу барилга байгууламжийн н-эг маягийн болон давтан хэрэглэх	2021-2024	Азийн хөгжлийн банкнаас санхүүжилт /10,856.41/	Зурга төсөл боловсруулах			

		зураг боловсруулах ажлыг байгуулна.	төсөл зохион							92.5%
--	--	--	-----------------	--	--	--	--	--	--	-------

Хэрэгжилтийн дундаж хувь

ХЯНАСАН:  
ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНСҮРЭН

Б.МӨНХЗАЯА



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2023 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 11 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн элийн хувь
<i>Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Иргэдийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эруул мэндээ хамгаалах, сайжруулах нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох/</i>							
1.1	Байгууллагын жил, улирлын календарчилсан төлөвлөгөөнд тусгагдах нэгжийн санал оруулах. -Сар, улирал, жилийн тайлан мэдээг холбогдох байгууллага, нэгжид хугацаанд нь хүргүүлэх	-	Сар, улирал, жилийн тайлан тоо	26	30	2023 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамирын 31 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 158,502 иргэн хамруулсан байна. Арга хэмжээний тайлан, мэдээг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.	100%
1.2	Нийслэл, дүүргээс зохион байгуулдаг "Өвлийн өдөрлөг" арга хэмжээнд оролцох, зохион байгуулах	Улсын төсөв: 8.170.0	Оролцогчдын тоо	1541	1600	161 байгууллагын 4250 ажилтан албан хаагч	100%
1.3	Явган аяллын арга хэмжээ /өсвөр үе, залуучууд, ахмад, болон албан хаагч нарын дунд/	Улсын төсөв: 14.815.0	Оролцогчдын тоо	200	250	Баянзүрх дүүргийн хэмжээнд өсвөр үе, ахмад, СӨББ, ЕБС, ЭМТ-ын ажилтан албан хаагчдын дунд нийт 5 тэмцээнийг зохион байгуулж 1,010 иргэн	100%
1.4	Цэцэрлэгийн хүүхдүүдийн "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв: 4.460.0	Оролцогчдын тоо	250	300	10 байгууллагын 300 тамирчин	100%

1.5	ЕБС-ын сурагчдын "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв: 3.515.0	Оролцогчдын тоо	450	500	7 сургуулийн 11 багийн 122 тамирчин	100%
1.6	Дүүргийн хэмжээнд "Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" авч, программд шивж оруулах	Улсын төсөв: 10.765.0	Сорилд хамрагдагчийн тоо	43324	43500	Дүүргийн 50,123 иргэн	100%
1.9	"Улаанбаатар Марафон", "Өртөөт марафон" арга хэмжээг дүүрэгт зохион байгуулах, оролцуулах	Улсын төсөв: 1.660.0	Оролцогчдын тоо	1700	2000	"Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийн тэмцээнд дүүргийн 2400 иргэн "Гүүг марафон" 43 хорооны 500 иргэн.	100%
1.10	"Дэлхийн алхалтын өдөр" аяныг зохион байгуулах	Улсын төсөв: 5.505.0	Оролцогчдын тоо	604	630	140 иргэн	100%
1.11	"Ажил танилцуулах" өдөрлөгийг зохион байгуулах, оролцох	-	Оролцогчдын тоо	200	220	250 иргэн	100%
1.12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдийн дунд 3 арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв: 15.240.0	Оролцогчдын тоо	410	450	580	100%
1.13	Иргэдийн спортын XI наадмыг дүүрэгтээ зохион байгуулж, шигшээ тэмцээнд баг тамирчдыг оролцуулах.	Орон нутгийн төсөв: 128.965.0	Оролцогчдын тоо	2100	2200	43 хорооны давхардсан тоогоор нийт 12,730 иргэн	100%
1.14	Арга хэмжээний үеэр "эрүүл зөв амьдрах дадал, хэвшилд сургах" зөвлөмж гарын авлага гарган тараах	Улсын төсөв: 2.000.0	Тараасан иргэдийн тоогоор	20000	25000	15,000	100%

1.15	Байгууллагуудын спорт хамтлагийн судалгаа, тайлан авч нэгтгэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх	-	Хамтлагийн судалгааны тоо	60	66	69	100%
1.16	СӨББ, ЕБС-ийн биеийн тамирын багш нарт сургалт зохион байгуулж сургалтад идэвхтэй хамруулах	Улсын төсөв: 3 300.0	Оролцогчдын тоо	250	300	СӨББ, ЕБС-ийн биеийн тамирын багш, арга зүйч нарын дунд 2 удаагийн сургалтыг 104 байгууллагын 179 багш, арга зүйч нар хамрагдсан.	100%
1.17	Арга хэмжээнд холбогдох Захирамж, шийдвэр гаргуулан, заавар удирдамж боловсруулж холбогдох байгууллагуудад хүргэх.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	30	35	31	100%
1.18	Зохион байгуулсан арга хэмжээний протокол, материал, хөтөлж, баримтжуулах, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлэх	-	Зохион байгуулсан, тэмцээнд оролцсон баримт, тоогоор	25	30	31	100%
1.19	Үйл ажиллагаатай холбогдох судалгааг гаргах, нэгтгэх, дүгнэх	-	Судалгааны тоо	4	5	3	100%
1.20	Хороодын арга зүйч, зохион байгуулагч нарын дунд цахимаар болно танхимаар сургалт зохион байгуулах	Улсын төсөв: 2 990.0	Сургалтанд хамрагдагчдын тоо	129	150	209	100%
1.21	Нийтийг хамарсан "Цахим" арга хэмжээ зохион байгуулах. Гимнастрада, Цахим гүйлтийн арга хэмжээ г.м/	-	Оролцогчдын тоо	45100	45200	867	100%

1.22	ЕБСургуулийн сурагчдын сагсан бөмбөг, волейболын "Улаанбаатар лиг" фестиваль	Улсын төсөв: 30.130.0	Оролцогчдын тоо	1638	1700	82 сургуулийн 21,820 тамирчин	100%
1.23	Биеийн тамирын үйл ажиллагаа явуулдаг клубүүдийн магадлан итгэмжлэлийн талаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх	-	Клубын тоо	2	3	3	100%
1.24	Цэцэрлэгийн багачуудын дунд арга хэмжээ зохион байгуулах /Үндэсний бөх, 100 буудалт даам/	Улсын төсөв: 590.0	Оролцогчдын тоо	80	90	18 байгууллага 62 тамирчин	100%
1.25	СӨББ, ЕБС, Хороодын биеийн тамир, спорт хамтлагийн дунд болзолт уралдаан зохион байгуулах	Улсын төсөв: 30.000.0	Биеийн тамир, спорт хамтлагийн тоо	55	60	60	100%
1.26	СӨББайгууллагын удирдлага болон ажилтан албан хаагч нарын 5 төрөлт арга хэмжээ	Улсын төсөв: 9.185.0	Оролцогчдын тоо	575	600	52 байгууллага 728 ажилтан, албан хаагч	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, дүүргийн Засаг даргын дэрээдэх өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг улс, бүс, олон улс, тив, дэлхийн түвшинд хүрээх							
2.1	- Байгууллагын жил, улирлын календарчилсан төлөвлөгөөнд тусгагдах нэгжийн санал оруулах - Сар, улирал, жилийн тайлан мэдээг холбогдох байгууллага, нэгжид хугацаанд нь хүргүүлэх	-	Сар, улирал, жилийн тайлан мэдээг хүргүүлсэн тоо	25	28	2023 оны жилийн эцсийн байдлаар 23 спортын уралдаан тэмцээн зохион байгуулж тайлан, мэдээг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээ.	100%

2.2	МУ-ын Засгийг газрын тогтоолоор зохион байгуулагдаг наадмууд: - "Монголын хүүхдийн спортын VII наадам"-ын анхан шатны тэмцээнийг зохион байгуулж шигшээ тэмцээнд заавар, журмын дагуу оролцуулах /спортын 17 төрөл/	Орон нутгийн төсөв: 75,369.8	Оролцогчдын тоо, авсан медаль, Байгууллагаар эзэлсэн байр.	Өмнөх наадамд 41 сургуулийн 3720 тамирчин оролцсон	50 байгууллага 4000 гаруй тамирчин	Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадамд дүүргийн 24 тамирчин оролцож Уулын цанын төрөлд 2 хүрэл медаль, Снеубордын төрөлд 4 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж нэгдсэн дүнгээр 17 дугаар байранд орлоо. Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын анхан шатны дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 182 сургуулийн 1802 сурагч оролцсон. Шигшээ тэмцээнд дүүргийн спортын 23 төрөлд 204 тамирчин оролцож 17 алт, 16 мөнгө, 37 хүрэл нийт 70 медаль хүртэж нийлбэр дүнгээр 3-р байрт жагслаа.	100%
2.3	Монголын бүх ард түмний спортын өвлийн "XVI наадам"-ын анхан шатны тэмцээнийг зохион байгуулж шигшээ тэмцээнд нэгдсэн зааврын дагуу дүүргийн тамирчдыг оролцуулах.	Орон нутгийн төсөв: 14,379.2	Оролцогчдын тоо, авсан медаль, Байгууллагаар эзэлсэн байр	Өмнөх наадамд Байгууллагын дүнгээр Нийслэлд 1-р байр	Амжилтаа ахиулна	-Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадмын шигшээ тэмцээнд дүүргийн 28 тамирчин оролцож Шайбтай хоккейн төрөлд мөнгөн медаль, Снеубордын төрөлд 1 мөнгөн медаль, 1 хүрэл медаль авч 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 9 дүгээр байранд орлоо.	100%
2.4	Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 17 төрлөөр зохион байгуулна. /шинээр хөгжиж буй 1 спортын төрлийг дэмжин ажиллах/	Улсын төсөв: 10,460.0	Оролцогчдын тоо	1200	1700	270 байгууллагын 2,451 тамирчин	100%
2.5	Залуучуудын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 3 төрлөөр зохион байгуулна	Улсын төсөв: 2 354.0	Оролцогчдын тоо	100	150	10 байгууллага 72 тамирчин	100%



2.6	Насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 4 төрлөөр зохион байгуулна	Улсын төсөв: 2 000.0	Оролцогчдын тоо	110	150	123 байгууллага 1,172 тамирчин	100%
2.7	Ахмадын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 2 төрлөөр зохион байгуулна.	Улсын төсөв: 1 575.0	Оролцогчдын тоо	110	150	12 байгууллага 30 тамирчин	100%
2.8	Хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг бэлтгэн оролцуулах, дэмжлэг үзүүлэх	-	Оролцогчдын тоо	200	210	436 тамирчин	100%
2.9	Дүүрэг, хот, улсын хороонд холбогдох тайлан мэдээг гаргаж өгөх.	-	Сар, улирал, жилийн тайлан мэдээг хүргүүлсэн тоо	25	28	25	100%
2.10	Дасгалжуулагч, биеийн тамирын багш нарт сургалт, семинар зохион байгуулах.	-	Зохион байгуулсан, оролцсон тоогоор	1	3	2	100%
2.11	Тэмцээн уралдааны заавар удирдамж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	55	70	25	100%
2.12	Зохион байгуулсан тэмцээн уралдааны протокол, материал, хөтөлж, баримтжуулах	-	Зохион байгуулсан, тэмцээнд оролцсон баримт, тоогоор	25	30	25	100%
2.13	Нэрэмжит тэмцээн зохион байгуулах	Улсын төсөв: 590.0	Оролцогчдын тоо	1500	1600	18 байгууллага 62 тамирчин	100%

2.14	Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийг удирдлагаар хангах, багийн тамирчдыг сэргэлтийн бэлтгэл сургуулилтад хамруулах	-	Бэлтгэлд хамруулсан тоогоор	8	9	30 тамирчин	100%
2.15	Дүүргийн шигшээ багуудын дунд спортын 1-2 төрлөөр багийн тэмцээн зохион байгуулах	-	Оролцсон багийн тоо	9	9	9	100%
2.16	Үйл ажиллагаатай холбогдох судалгааг гаргах, нэгтгэх, дүгнэх	-	Судалгааны тоо	4	5	5	100%
Зорилго-3: Төрийн байгууллагын чиг үүргийг хангах							
3.1	Арга хэмжээ-1: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтэд, тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хууль, журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан хүргүүлсэн тоо	Улиралд 1 удаа	4	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтын дагуу гарган батлуулж, хэрэгжилтийг ханган тайлагнан ажиллалаа.	100%
3.2	Арга хэмжээ-2: Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах	-	Тогтоол шийдвэрийн тайлан хүргүүлсэн тоо	Улиралд 1 удаа	4	Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох тайлан мэдээг дээд шатны байгууллагад заавар журмын дагуу хүргүүлэн ажиллалаа.	100%
3.3	Арга хэмжээ-3: Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах	-	Сургалтад хамрагдсан ажилтны тоо	Мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдаад байна.	2 албан хаагч нэмж хамрагдана	-Бүтэц орон тоо нэмэгдсэнээс оффисын хэрэглэл материал, компьютер тоног төхөөрөмж дутагдалтай байгаагаас Дүүргийн ЗДТГ-аас 2023 оны жилийн эцсийн байдлаар 2ш суурин иж бүрэн, 2ш зөвөрийн	100%

	<p>нийт 4ш шинэ компьютерээр ажилтен албан хаагчдаа хангаад байна. Мөн дахин улсын төсвийн санхүүжилтээр хангуулахаар хүсэлт өгсөн.</p>				
3.4	<p>Арга хэмжээ-4: Байгууллагын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>Тухай жилийн улсын болон орон нутгийн батлагдсан төсөв</p>	<p>Жил бүр батлагдсан төсвийг хуулийн дагуу захиран зарцуулж байна.</p>	<p>Шилэн дансны тухай хууль болон төсвийн тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдлыг ханган тайланг хуулийн хугацаанд тайлагнасан байна</p>	<p>Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хууль дүрмийн дагуу явагдаж байна. Гүйцэтгэлийг тайлагнан ажиллагаа.</p> <p>100%</p>
3.5	<p>Арга хэмжээ-5: Дүүргийн хэмжээнд Биеийн тамир спортын үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын үйл ажиллагааны, үнэлгээг тогтмолжуулж, зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих</p>	<p>Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнэлт зөвлөмж хүргүүлэх тоо</p>	<p>Дүүргийн хэмжээнд биеийн тамир, спортын үйл ажиллагаа явуулдаг 61 спортын клуб, фитнес клубүүдэд 1 удаа хяналт явуулан зөвлөмж хүргүүлсэн</p>	<p>2023 онд- 1-2 удаа</p>	<p>1 удаа</p> <p>100%</p>
3.6	<p>Арга хэмжээ-6: Байгууллагын дотоод хяналт шалгалтын комиссын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах</p>	<p>Дотоод хяналт шалгалтын комиссоос гаргасан тайлан мэдээний тоо</p>	<p>30</p>	<p>33</p>	<p>Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах</p> <p>100%</p>

					<p>нийтлэг журам"-ын биелэлтийг хангах ажлын хүрээнд байгууллагын ажилтан албан хаагчдын Жилийн ажлын төлөвлөгөө болон хувийн төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулж, улирал бүр үр дүнг тайлагнан ажиглаж байна. 2023 оны 03 дугаар сард Дотоод хяналт шалгалтын комиссоос байгууллагын ажилтан, албан хаагчдын ажил дүгнэх явцад ажиглагдсан зөрчил дээр үндэслэн зөрчил арилгах санал боловсруулж саналын дагуу ажлын гүйцэтгэлийг дүгнэн хийгдээгүй ажлыг шахаж хийлгэхээр хугацаа өгөн ажиллалаа.</p>
--	--	--	--	--	---

  
 (гарын үсэг)  
 0117 0051

Тайлане хянасан:

Төсвийн Шууд захирагч  
(албан тушаал)

(огноо)

..... / Д.ОТГОНСҮРЭН /

Тэмдэг

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороо

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**  
/2023 оны 4 дүгээр улирлын байдлаар/

2023 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчгүй болон, хяналтаас хасуулах тухай)	Tасарсан болон удааширч байгаа шалтгаан
<b>НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>					
1.	8 дугаар зүйл 8.1.1-8.1.8	Биеийн тамир, спортын тухай хууль 2017.07.06 Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх 8.1.1. харьяа нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	-Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 100%		
2.	8 дугаар зүйл 8.1.1-8.1.8	8.1.2. харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх	2023 оны 4 дүгээр улирлын байдлаар Биеийн тамирын 31 арга хэмжээ, Спортын 23 уралдаан тэмцээн зохион байгуулж нийт давхардсан тоогоор 161,326 иргэнийг идэвхтэй хөдөлгөөнд хамруулж, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. 100%		
3.		8.1.3. биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх	2023 оны байдлаар Биеийн тамирын 31 арга хэмжээ, Спортын 23 уралдаан тэмцээн зохион байгуулж шагналт байранд шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. -Жилийн эцэст биеийн тамир, спортыг дэмжигч аж ахуйн нэгж байгууллага, дасгалжуулагч, тамирчдыг 13 номинацаар "Оны		

	шилдэг"-үүдийг шалгаруулж байгууллагын хурлаар хэлэлцэж шалгаруулан урамшуулна. 100%			
4.	<p>- Биеийн тамирын хэлтсээс "Жин хасах" хөтөлбөр гарган хэрэгжүүлж нийт 60 иргэн хамрагдлаа. Мөн спорт хамлагийн дунд дүүргийн хэмжээнд Биеийн тамир, спортын хамтлагийн болзолт уралдааныг зарлаж хагас, бүтэн жилээр тайланг авч нэгтгэн, дүгнэж шалгарсан хамтлагуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Болзолт уралдаанд 60 хамтлаг оролцож нийт 51,000 иргэнийг хамтлагийн үйл ажиллагаагаараа дамжуулан идэвхтэй хөдөлгөөнд татан оролцуулсан байна. 100%</p>	8.1.5.биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах;		
5.	-Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт цогцолборын барилгын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.	8.1.6.хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх;		Төсөв хүрэлцээгүй улмаас зогсонги байдалд орсон
6.	Төрийн болон төрийн бус байгууллагууд мөн ААН-үүдтэй хамтран ажиллаж БТСХ-ны зүгээс болон тэдгээр байгууллагуудын санаачлагаар зохион байгуулж байгаа нийтийг хамарсан спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө тогтмол хүргэж байна. Жилийн эцсийн байдлаар БНСУ-ын Кёнбүк хотын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Суугаа Волейболын холбоо, Монголын параволейболын холбоо, Монголын сагсан бөмбөгийн холбоо, Монголын 3х3 Сагсан бөмбөгийн холбоо, Волейболын холбоо, Баянзүрх дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, Хөл бөмбөгийн холбоо, Боксын холбоо, Шатрын клуб, Ширээний теннисий клуб, Таеквондогийн клуб, 100 буудалт дээмний клуб гэх мэт нийт 16 холбоо болон клубуудтэй хамтын ажиллагаатай ажиллаж байна. 100%	8.1.7.биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах;		
7.	Дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн А/973 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 14-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна. Өсвөрийн шигшээ багийн 14 төрөлд нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 234 тамирчин Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад	18.5.Аймаг, дүүргийн Засаг дарга нь аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь спортын 8-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь		

	салбартай хамтран сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь зохион байгуулна.	шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллүүлж байна. 100%	100%
<b>Хэсгийн дундаж</b> <b>ХОЁР. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
8.	<p>Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай 2010.03.26 №53</p> <p>1. Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.</p> <p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022.04.05 Дугаар 43</p> <p>1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах.</p>	<p>-Дүүргийн иргэдийн дунд бие бялдрын түвшин тогтоох сорилыг 1 сарын хугацаанд дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран Сорилын төв байгуулж ажиллалаа. "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд СӨББ, ЕБС, Хороод, Аж ахуй нэгж байгууллага, иргэд нийт 107 байгууллагын <b>50,123</b> иргэн хамрагдсан байна. 100%</p>	
11.	<p>1.8.</p>	<p>-Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар, 19-р хороо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлтэй хамтран иргэд, залуучуудын Бид хамтдаа спортын 3 төрөлт тэмцээн, Хороодын 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, Сонсголгүй иргэдийн 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг заал зохион байгуулалтаар ханган, дэмжин ажиллалаа. Нийт 350 иргэн оролцож чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүллээ.</p> <p>-Мөн Нийслэлийн хэмжээнд "Суугаа волейболын тэмцээнийг Солонгос улсын Параволейболын холбоотой хамтран зохион байгуулж 9 багийн 80 иргэн оролцлоо.</p> <p>-Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Баянзүрх дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, БНСУ-ын Кёнбүк хотын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Суугаа Волейболын холбоо цаашид хамтран ажиллахаар болж санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичгийг байгуулснаар цаашид хоёр улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, тодорхой ажлуудыг хамтран зохион байгуулж ажиллахаар боллоо. 100%</p>	100%
<b>Хэсгийн дундаж</b>			

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

12.	Нэг	<p>Журам шинэчлэн батлах тухай 2017.02.15 №57</p> <p>1. "Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.</p>	<p>Монголын коллежуудын цоглог оюутан сагсан бөмбөгийн холбоотой хамтран БЗД-ийн ЕБС-ийн сурагчдын 3x3 сагсан бөмбөгийн тэмцээн, БЗД-ийн 43 хороодын иргэдийн 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнийг хамтран зохион байгуулах гэрээ байгуулан ажилласан. 100%</p>	
13.	Хоёр	<p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018.05.23 138</p> <p>Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернет сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг,</p>	<p>-Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын ер.ulaanbaatar.mn, ХНУМТ-ийг хөтлөн, тухай бүр өөрчлөлтийг бүртгэн ажиллаж байна. EDOC албан хэрэг хөтлөлтийн системийг өдөр бүр ашиглан шилжүүлэлт, шийдвэрлэлт цаг тухай бүрт хийгдэж байна.</p> <p>-Мөн санхүүгийн cts.mn, finance.gov.mn програмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 100%</p>	
14.	2.	<p>Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам батлах тухай 2018.06.20 №183</p> <p>2. Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжин улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган, шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>- Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу дүүргийн Засаг даргын А/29 дугаар захирамж гарч хэрэгжилтийн ханган Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын анхан шатны дүүргийн аварга шалгаруулах тэмцээний төсвийг Засаг даргаар батлуулан зохион байгуулж ажилласан.</p> <p>Анхан шатны дүүргийн тэмцээнд төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нийт давхардсан тоогоор 182 сургуулийн <b>1802</b> сурагч оролцсон байна. 100%</p>	
		<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг сахин 2018.08.22-ны 258 дугаар тогтоол</p> <p>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга,</p>	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг сахин ажиллаж байна. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар зөрчилгүй ажилласан.</p>	



15.	1.1	Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай. 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	100%		
16.	1.1- 1.10 ба 3	1.3. Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	2023 онд 13 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Ажлын байрны шинжилгээгээр чиг үүргийн давхардал гараагүй. 100%		
17.	5.1-5.5	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 №07 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай. 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, томилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хоёр бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг	- Ажилтан, албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монгол хэл, бичгийн журамласан үгийн тайлбар сэдвээр БЗД-ын насан туршийн болсвсролын төвөөс 1 удаагийн сургалтад хамрагдлаа. 100%		

		<p>Дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;</p> <p>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх;</p> <p>Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022.06.11 Дугаар 187</p>		
18.	1.1.	<p>1.1. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт;</p>	<p>Байгууллагын хэмжээнд 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өргөдөл, гомдол ирээгүй байна. 100%</p>	100%
<b>Хэсгийн дундаж</b>				
<b>ТАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР.</b>				
19.	1.1-1.5	<p>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>2017.10.26 №01</p> <p>1.1.Иргэндээ ээлтэй хуулийн засаглалын бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах.</p> <p>1.2.Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх.</p> <p>1.3.Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал</p>	<p>-Албан тушаалын сахилга хариуцлагыг өндөржүүлж, албан ажил, гарсан асуудлыг цаг алдалгүй хурдан шуурхай шийдвэрлэх, зохион байгуулах, төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 1 албан хаагч сахилгын зөрчил гаргасан тул хариуцлага тооцон ажиллалаа. 100%</p>	

	<p>гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах.</p> <p>1.4.Төрийн албаны үр ашгийг сайжруулах. Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих.</p> <p>1.5.Бодлогын тогтвортой байдлыг хангах. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.</p>		
<b>Хэсгийн дундаж</b>			
<b>ЗУРГАА. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ</b>			
<p>20.</p> <p>Нэг, гурав, дөрөв дүгээр заалт</p>	<p>Хамтлаг байгуулах тухай 2006.04.11 №165 Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, хороо тус бүрт Биеийн тамир, спортын хамтлагийг байгуулан ажиллуулсугай.</p>	<p>- 2023 онд Спорт хамтлагийн судалгааг шинэчлэн авлаа. Дүүргийн хэмжээнд 30 хамтлаг шинэчлэн байгуулагдаж нийт 63 хамтлаг үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.</p> <p>Биеийн тамир, спортын газрын 2017 оны 03 дугаар сарын 23-ны А/82 дугаар тушаал Биеийн тамир, спортын хамтлаг байгуулах тухай, Нийслэлийн засаг даргын 2007 оны А/165 дугаар захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн хороод, СӨББ, ЕБСургууль, ААНэгж байгууллага гэсэн 4 чиглэлд Биеийн тамир, спортын хамтлагийн болзолт уралдааныг зарлаж тайлан мэдээг авч нэгтгэн дүгнэж урамшууллаа.</p> <p>100%</p>	<p>100%</p>
<p>21.</p>	<p>"Улаанбаатар марафон зохион байгуулах тухай" 2023.03.30 А/302</p>	<p>-Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 03-р сарын 30-ний өдрийн А/302 дугаар захирамжын хүрээнд дүүргийн хэмжээнд Бүртгэлийн штаб байгуулж 2023 оны 04 дүгээр сарын 01-ээс 2023 оны 06 дугаар сарын 03-ний өдрүүдэд аж ахуй нэгж байгууллага, ЕБС, СӨББ, Хороод, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Иргэдэд "Улаанбаатар марафон 2023" олон улсын гүйлтийн тэмцээний зохион байгуулалт, бүртгэлийн мэдээ мэдээллийг өгч ажиллалаа. Дүүргийн 2400 иргэн энгэрийн номер дугаараа баталгаажуулан авч Улаанбаатар марафон-2023 олон улсын гүйлтийн тэмцээнд оролцсон байна.</p> <p>100%</p>	

Хэсгийн дундаж	100%
НИЙТ ДУНДАЖ	100%

ХЯНАСАН:  
ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНСҮРЭН

Б.МӨНХЗАЯА



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2021-2024 ОНЫ  
 УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ  
 /Баянзурх дүүргийн Биеийн тамир, спортын хороо/

2023 оны 11 дүгээр сарын 24

Улаанбаатар хот

НЭДҮАХ-Т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ эх үүсвэр/ 2023 он		Хэрэгжилтийн хувь
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
<b>2.2. Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.</b>								
2.2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1.	2.2.1.1. Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны боловсронгуй удирдлага байгуулалтыг сайжруулна.	2021-2024	НСХ	-	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	100%
	2.	2.2.1.2. Дүүргүүдийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлнэ.	2023-2024	НСХ	-	Санал хүргүүлсэн байна.	ЗГТА-БТСУХороонд санал хүргүүлсэн болно. Баянзурх дүүрэг 43 хороотой болсон.	30%
	3.	2.2.1.3. Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	НСХ	-	Магадлан итгэмжлэгдсэн 2 спорт клуб шинээр нэмэгдүүлсэн байна.	Баянзурх дүүрэгт спортын 3 клуб магадлан итгэмжлэгдсэн байна. Одоогоор улсын хэмжээнд магадлан итгэмжлэлд хамруулах ажил явагдаагүй байна.	100%

2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын	4.	<p>2.2.1.4. Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдийн сролцрог нэмэгдүүлнэ. Улаанбаатар Марафон, Иргэдийн Спортын наадам, Төрийн албан хаагчдын наадам гэх мэт/</p>	2021-2024	НСХ	146.205.0	<p>Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдын тоог 33,000 хүнээр нэмэгдүүлж 347,196-д хүрсэн байна.</p>	<p>- "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийн тэмцээнд дүүргийн 2400 иргэн оролцсон.</p> <p>- Иргэдийн спортын XI наадмыг Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/650 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 11-ны хооронд Сагсан бөмбөг, Волейбол, Дартс, Ширээний шагайн наадгай, Олс таталт, Аэробик, Хийн дасгал, Явган аялал, Софт волейбол гэсэн 9 төрлөөр амжилттай зохион байгуулагдаж 43 хорооны давхардсан тоогоор нийт 12,730 иргэн хамруулан ажиллалаа.</p> <p>- Дүүргийн иргэдийн дунд Төрийн албан хаагчдын 7 төрөлт тэмцээн, Биеийн тамир, спортын хамтлагийн болзолт уралдаан, Жин хасах хөтөлбөр, Гүүг марафон, Алхацааа гүйцгээ хөдөлгөөн гээд томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 160 байгууллагын 53,610 иргэн хамруулсан байна.</p>	100%
2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын	5.	<p>2.2.1.5. Өвлийн зохин байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ.</p>	2021-2024	НСХ	8.170.0	<p>Өвлийн улиралд биеийн тамираар хичээллэгч, арга хэмжээнд оролцогчдын тоог 1,000 хүнээр нэмэгдүүлж 411,000-д хүрсэн байна.</p>	<p>Баянзүрх дүүргийн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/28 дугаар захирамжийн хүрээнд "Баянзүрх өвлийн өдөрлөг-2023" арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 04-ны өдөр Гачуурт тосгон Монгол шилтгээнд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 43 хороо, 51 СЭББайгууллага, 39 ерөнхий боловсролын сургууль, 28 хэлтэс албадын 161 байгууллагын 4,250 ажилтан албан хаагч нар хамрагдлаа.</p>	100%
2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын	6.	<p>2.2.2.1. Багийн спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн</p>	2021-2024	НСХ	53.270.0	<p>Багийн спортын төрлөөр зохион</p>	<p>Дүүргийн хэмжээнд багийн спортын төрлөөр "Улаанбаатар лиг сагсан бөмбөгийн фестиваль", "Улаанбаатар лиг волейболын фестиваль", Мөрөөдлийн гоол "2022-2023"</p>	100%

<p>терлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.</p>	<p>тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.</p>			<p>байгуулсан тэмцээн, уралдаанд оролцогчдын тоог 100 хүнээр нэмэгдүүлж 145,100-д хүрсэн байна.</p>	<p>Хөл бөмбөг, Дүүргүүдийн өсвөрийн шигшээ Чөлөөт бөхийн эмэгтэй багуудын тэмцээн, ЕБС-ийн өсвөр үеийн суралгчдын спорт явган аялал, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, СӨББ, ЕБС-ийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнүүдийг зохион байгуулж 23,172 өсвөрийн тамирчид оролцлоо.</p>	
<p>7.</p>	<p>2.2.2.2. Биеийн тамир, спортын төрийн болон төрийн байгууллагуудын туншлалд тулгуурлан спортын уралдаан тэмцээнүүдийн чанар зохион байгуулалтыг сайжруулна.</p>	<p>2021-2024</p>	<p>НСХ</p>	<p>Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчдын тоог 38 тамирчнаар нэмэгдүүлж 7,134-д хүргэсэн байна.</p>	<p>Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд дүүргийн баг тамирчид Жүдо бөх, Даам, Сагсан бөмбөг, Волейбол, Самбо бөх, Байт харваа, Хүндийн өргөлт, Бокс, Таеквондо, Уран хөдөлгөөнт гимнастикийн төрлүүдээр нийт 436 тамирчин оролцсон.</p>	<p>100%</p>
<p>8.</p>	<p>2.2.2.4 Зүүн Азийн Залуучуудын Анхдугаар наадмыг өндөр түвшинд зохион байгуулна</p>	<p>2023</p>	<p>НСХ</p>		<p>Зүүн Азийн Залуучуудын Анхдугаар наадамд Манай байгууллагаас 3х3 сагсан бөмбөгийн спортын зохион байгуулалтад 1, Dopping control officers 2, Чөлөөт бөхийн ерөнхий шүүгчээр 1 ажилтан нийт 4 албан хаагч оролцлоо.</p>	<p>100%</p>
<p>9.</p>	<p>2.2.2.5 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>2021-2024</p>	<p>НСХ</p>	<p>Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл суурь түвшинг хэвээр хадгална.</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн А/973 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 14-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.</p>	<p>100%</p>

10.	2.2.3.2. Нийслэл болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол, Багахангай дүүргийн спортын 6 цогцолборыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	НСХ	-	Спортын цогцолборыг ашиглалтад оруулсан байна.	Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт цогцолборын барилгын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.	85%
11.	2.2.3.4. Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засна.	2021-2023	НЗДТГ, НГЗБА	-	Хэлбэгдох судалгааг хийнэ.	Баянзүрх дүүргийн хэмжээнд нийтийн эдэлбэр газар, хуучин талбайнууды сэргээн засаж ашиглалтад оруулсан талбайн судалгааг 2023 онд авсан. Судалгаагаар 16ш 3х3 талбай дэмжье ажлын хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон байна.	100%
12.	2.2.3.5. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайнуудыг стандартын дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосныг цуцалж, сургуулийн эзэмшил газарт нь нэмж баталгаажуулна.	2022-2024	НГЗБА, НБГ	-	-	Баянзүрх дүүрэгт Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын 18 талбай судалгаагаар гарсан.	100%
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ:							92,9%

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:  
ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНСҮРЭН

Б.МӨНХЗАЯА





## АГУУЛГА

<b>НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....</b>	<b>3</b>
1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт.....	3
1.2.“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал.....	3
1.4.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал.....	3
✓ СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН	5
✓ БИЕИЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ	24
1.5.Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт.....	65
1.6.Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.....	65
1.7.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн.....	66
1.8.Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн.....	68
<b>ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН.....</b>	<b>71</b>
2.1. Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн.....	71
2.2. Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилт, үр дүн....	71
2.7.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал.....	71
2.8.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал.....	71
2.9.Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн.....	74
<b>ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....</b>	<b>74</b>
3.1.Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн.....	74
3.2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн.....	4



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### АЛСЫН ХАРАА


Дүүргийн нийт хүн амд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, өсвөрийн болон бусад тамирчдын амжилтын түвшинг дээшлүүлэх, биеийн тамир спортоор дамжуулан оюун санааны сэргэлт, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Биеийн тамир спортын тухай болон бусад хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт спорт, нийтийн биеийн тамирын талаар тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, дүүргийн иргэдэд спорт, биеийн тамирын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд оршино.

### БҮТЭЦ, ОРОН ТОО

Баянзүрх дүүргийн засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/726 захирамжаар Биеийн тамир, спортын хорооны бүтэц орон тоог 15 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг гарган томилон ажиллаж байна.





## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2023 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

### НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

#### 1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар марафон, Алхацгаая - гүйцгээе хөдөлгөөн, Улаанбаатар лиг ЕБС-ийн сурагчдын сагсан бөмбөгийн фестиваль, ББХЧТТ сорил, Иргэдийн спортын наадам томоохон арга хэмжээнүүдийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж 383 байгууллагын 87,341 иргэн хамруулсан.

#### 1.2. “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал

*2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.*

- 2023 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамирын 31 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор **1,219** байгууллагын **158,502** иргэн хамруулсан байна.

Дүүргийн иргэдийн дунд эрүүлээр жингээ хасах, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжих, дархлаажих, алхалт, гүйлтийн ач холбогдол, эрүүл хооллолт, эрүүл бие, эрүүл зөв амьдралын хэв маяг, спортын бэртэл гэмтэл, Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, Энэ жилдээ-Эрүүл жиндээ 18 нэр төрлийн зөвлөмж, мэдээллийг бэлтгэн **12,000** гарын авлагыг хэвлэн иргэдэд тараан сурталчлах ажлыг зохион байгуулсан.

#### 1.4. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал

*Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь “Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина”.*

*-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 заалтын дагуу дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтад оруулна ажлын хүрээнд:*

-Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт цогцолборын барилгын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.

*-НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.5 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5 заалтын Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар ханган дэмжлэг үзүүлнэ ажлын хүрээнд:*



Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн А/973 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 14-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

Өсвөрийн шигшээ багийн төрөлд:

1. Жү-до бөх	8 . Спортын гимнастик
2. Чөлөөт бөх	9. Даам
3. Самбо бөх	10. Байт харваа
4. Бокс	11. Ширээний теннис
5. Тэшүүр	12. Волейбол
6. Хүндийн өргөлт	13. Сагсан бөмбөг
7. Хөнгөн-Атлетик	14. Таеквондо гэх мэт спортын төрлөөр үйл ажиллагаа явуулж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар (Жү-до бөх, Самбо бөх, Чөлөөт бөх, Бокс, Волейбол, Ширээний теннис, Даам, Сагсан бөмбөг 3х3, 5х5, Хөнгөн-Атлетик, Таеквондо, Хүндийн өргөлт) төрлүүдээр нийт 23 спортын, уралдаан тэмцээнийг зохион байгуулж **406** байгууллагын **2,824** тамирчин оролцлоо.

*-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2 заалтын дагуу Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:*

Дүүргийн хэмжээнд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмолжуулан иргэд, ажилтан албан хаагчдын бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлж хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэхэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг улам сайжруулж, тэднийг биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөний ач холбогдол, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, Баянзүрх дүүргийг ТҮМЭН дасгалыг сурталчлагч загвар дүүрэг болгох зорилгоор “Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн ТҮМЭН дасгал”-ын сургагч багш бэлтгэх, мэргэжил арга зүйн сургалтыг БЗД-ийн БТСХ-оос НЭМҮТ, ЭМТ-тэй хамтран СӨББ, ЕБС, Хороодын дунд амжилттай зохион байгууллаа. Цахим арга хэмжээнд нийт **63** байгууллагын **2500** гаруй арга зүйч , багш, сурагч, эмч нар хамрагдлаа.

Төрийн болон төрийн бус байгууллагууд мөн ААН-үүдтэй хамтран ажиллаж БТСХ-ны зүгээс болон тэдгээр байгууллагуудын санаачлагаар зохион байгуулж байгаа нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол хүргэж хэвшсэн. Дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан, албан хаагчдад 5, 9 сард ажлын өдрүүдэд өглөөний дасгалыг зааж, хэвшүүлэн, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд уриалах ажлыг зохион байгууллаа.

2023 онд 3 арга хэмжээг онцлон шинээр санаачлан хэрэгжүүлэн ажиллалаа.

1. Биеийн тамир, спорт хамтлагуудын дунд **“Спортын хамтлагийн болзолт уралдаан”**-ыг зарлан явуулж энэ хүрээнд дүүргийн спорт хамтлагууд олон төрлийн спортын арга хэмжээг явуулсан. Болзолт уралдаанд нийт 60 хамтлаг оролцож 51,000 иргэнийг хамтлагийн үйл ажиллагаандаа татан оролцуулж, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
2. Дүүргийн иргэдийн дунд **“Жин хасах хөтөлбөр”**-ийг боловсруулан хэрэгжүүллээ. Жин хасах хөтөлбөрт 60 иргэн идэвхтэй оролцлоо.
3. Дүүрэгт **“Гүүг марафон”**-ыг анх удаа зохион байгуулж 43 хорооны 500 иргэн оролцсон байна.



## СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН

*-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.5 заалт - “Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өрөгжүүлнэ”, 2.2.2.1, 2.2.2.2 заалтууд, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 заалт- “Спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ” ажлын хүрээнд:*

-Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжийн дагуу батлагдсан орон тооны дагуу Спортын хэлтэс бүрэн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүүрэгт зохион байгуулагдах тэмцээн уралдааны заавар удирдамж гаргаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд хүргүүлэн мэдээ мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

- Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын дагуу 2023 онд Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадам “Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт” уриан дор 2023 оны 02 дугаар сарын 06-13-ны хооронд Орхон аймгийн Эрдэнэт хотод гүйлтийн цана, уулын цана, гүйлтийн тэшүүр, шорт трейк, шайбтай хоккей гэсэн зургаан спортын төрлөөр 19 аймаг, 9 дүүргийн 700 гаруй тамирчид дасгалжуулагчид оролцсон байна. Үүнд Баянзүрх дүүргийн 69 тамирчин оролцлоо. Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Шайбтай хоккейн төрөлд Г.Тамир ахлагчтай баг мөнгөн медаль, Снөүбордын төрөлд 1 мөнгөн медаль, 1 хүрэл медаль авч 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 9 дүгээр байранд орлоо. Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадамд дүүргийн 24 тамирчин оролцож Уулын цанын төрөлд 2 хүрэл медаль, Снөүбордын төрөлд 4 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж 17 дугаар байранд орсон амжилт үзүүлээ.

### Монголын хүүхдийн спортын VII наадмын анхан шатны тэмцээн

